

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
7 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2020.07.23

ГАЗАР ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Газар зохион байгуулалт, төлөвлөлт, өмчлөлийн чиглэлээр:

Аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд Сүмбэр сумын 4 дүгээр баг Өехийн гудамжинд газар өмчлөсөн 800 иргэний хувийн хэргийг хувилж цахим буюу DVD дээр хуулбарлан хүргүүлэв.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт баг байгуулсан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, хурлын тэмдэглэлийг аймгийн архиваас шүүн хувиан 02/258 дугаартай албан бичгээр хүргүүлэв.

Кадастрын чиглэлээр:


Агентлагын даргын 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 1/1509 дүгээр албан бичгээр төрийн өмчийн газрыг зурагжуулж, бүртгэлжүүлэх компаниуд ажил гүйцэтгэх гэрээгээ байгуулан ажилласан тухай албан тоот ирсэн.

Уг албан тоотоор гүйцэтгэгч компаниуд дараах ажил үүргийг гүйцэтгэн ажиллах бөгөөд гүйцэтгэгч компаниудад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллийг зохих журмын дагуу гаргаж өгөх үүрэг, чиглэл өгсөн.

- Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэлгэрэнгүй ангиллын тооллого явуулах, зураглах
- Төрийн өмчийн газрыг зурагжуулж бүртгэн, газрын кадастрын мэдээллийн санд оруулж, баталгаажуулах
- Зөвшөөрөлгүй газар ашиглаж буй зөрчлийг газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр илрүүлэх, судалгаа хийх, зөрчил арилгах арга хэмжээг тодорхойлох
- Өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын тооллогыг шинэчлэн хийх, зөрчилтэй нэгж талбаруудын зөрчлийг тодорхойлох
- Газрын суурь үнэлгээг тогтоох зэрэг ажлуудыг гүйцэтгэн ажиллах юм.



Мөн аймгийн Засаг даргын захирамжаар 2011-2020 онуудад газар эзэмших, ашиглах эрхийг дуусгавар болгосон нийт 43 хувийн хэргийг нэг бүрчлэн скайнердан цахим архив үүсгэн архивлан ажиллаж байгаа бөгөөд аймгийн Засаг даргын захирамжаар газар эзэмшиж, ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг нарийн гаргахаар ажиллаж байна. Мөн эзэмшил газраа өмчилсөн иргэдийн хувийн хэргийг бүртгэл хөтлөн өмчлөлийн мэргэжилтэнд шилжүүлэхээр бүртгэлийг үйлдэн ажиллаж байна.



Газрын төлбөр татвар, үнэлгээ, мониторингийн чиглэлээр:


“Үндэсний хэмжээний газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтийн үнэлгээ” хийх ажлын хүрээнд 2 удаагийн “Openforis, Collect earth” програмын онлайн сургалтанд хамрагдан аймаг тус бүрт үнэлгээ хийх цэгүүдийг хувиарлан өгсөн. Тус үнэлгээ хийх 5203 цэгээс 838 цэг дээр үнэлгээ хийж ажилласан.



Мэргэжилтны 3 дугаар улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг гаргасан.

Аймгийн хэмжээнд газар эзэмшигч, ашиглагчдын судалгааг гарган татварын хэлтэст хүргүүлсэн.

2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 6 байршилд газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг зохион байгуулах тухай зар мэдээллийг газрын цахим бирж болон өнөөдөр сонинд зарыг байршуулж олон нийтэд мэдээллэсэн.



Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгаа хийлгүүлэх 31 аж ахуй нэгж байгууллагын 59 нэгж талбарт албан тоот хүргүүлсэн.

Шивээговь сумын газрын даамлын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн.



Геодези, зураг зүйн чиглэлээр :

Геодезийн цэг тэмдэгийн тооллогын ажлын хүрээнд ГХБХБГ-ын даргын 2020 оны 06 дугаар сарын 16-ны өдөр геодезийн хатуу цэг тэмдэгтийн тооллого бүртгэл зохион байгуулах ажлын удирдамжийг батлуулан ажилласан.

Тус удирдамжийн дагуу Шивээговь, Баянтал, Сүмбэр сумын нутагт дэвсгэрт тооллогыг зохион байгуулан ажилласан байна.Үүнд:

80 цэг тэмдэгт газар дээр нь явж бүртгэл хийснээс 8 цэг тэмдэгт утсан олдоогүй байна.



Аймгийн наадмын баярыг угтан төв цэнгэлдэх хүрээлэнгийн тохижилтийн ажилд оролцон ажилласан. Хэмжил хийх хуваарийн дагуу нийт 8-н иргэний хэмжилт хийн ажилласан.



Мөн Сүмбэр сумын Газрын даамал Сүмбэр сумын 5-р багийн нутаг дэвсгэрээс явж өвөлжөө хаваржааний цэг нь мэдээллийг нэг бүрчлэн авч ажилласан.



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Барилга захиалагчийн хяналтын чиглэлээр:

1. Ариутгах татуурга өргөх станц

Байгууламжийн мэдээлэл: цутгамал төмөр бетон 5,9х4,9х5,9мхэмжээтэй 2160 м3/хон бохир татан зайлуулах

Ажлын гүйцэтгэлийн талаархи мэдээлэл: бүрэн цутгамал төмөр бетон каркасын ажил хийгдэж дууссан. Нийт ажлын гүйцэтгэл 55%-тай



2. Тэрэгтийн усан хангамжийн эх үүсгэвэр өргөтгөл, 2-р багийн айл өрх цэвэр усны шугамд холбох ажлын эхлэл

Ажлын гүйцэтгэлийн талаархи мэдээлэл: 1000м3, 250м3х2, хлорын барилга өгөх гаргах худаг, ус түгээх худгийн барилгын ажил 80%-тай, төв магистраль шугамын ажил ф200-150мм хуванцар 80%-тай, гадна цахилгаан хангамжийн ажил хийгдэж дууссан байна. Нийт ажлын гүйцэтгэл 80%-тай.



3. Дуганы барилга

Байгууламжийн мэдээлэл: цутгамал төмөр бетон каркас, тэнхлэгээрээ 17х17м хэмжээтэй 1 давхар дуганы өндөр 11,25м

Ажлын гүйцэтгэлийн талаархи мэдээлэл: цутгамал төмөр бетон каркасын ажил дууссан гадна сайдинг фасад дээврийн ажил, дотор заслын ажил 90%-тай хийгдэж байна. Нийт ажлын гүйцэтгэл 75%-тай



4. 150 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл /ТӨСӨЛ/

Барилгын мэдээлэл: Уг барилга нь тэнхлэгээрээ 21х10,2м хэмжээтэй 2 давхар барилга юм.

Ажлын гүйцэтгэлийн талаархи мэдээлэл: 1,2-р давхарын төмөр бетон каркасын ажил дууссан. Парапед, гадна ханын өрлөг өрөгдөж байна. Нийт ажлын гүйцэтгэл



55%-тай

5. 150 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл /БСШУСЯ/

Барилгын мэдээлэл: Уг барилга нь тэнхлэгээрээ 21х10,2м хэмжээтэй 2 давхар барилга юм.

Ажлын гүйцэтгэлийн талаархи мэдээлэл: төмөр бетон багана, шугаман суурь, 1,2-р давхар төмөр бетон каркасын ажил дууссан. 2019 онд гадна дулаан цэвэр усны шугамын ажил 50%-тай гадна цахилгаан 100% хийгдсэн байна. Нийт ажлын гүйцэтгэл 55%-тай.



6. 640 хүүхдийн сургуулийн барилга

Барилгын мэдээлэл: Уг барилга нь тэнхлэгээрээ 30х12,5м хэмжээтэй 2 блок, 18х24м хэмжээтэй 1 блок, 30х21 хэмжээтэй 1 блок нийт 4 блокоос бүрдэнэ. Зооргүй 3 давхар барилга юм. А,Б,В- блок анги танхим, багш ажилчдын өрөө Г-блок хоолны зал гал тогоо, спорт заал зориулалттай.

Ажлын гүйцэтгэлийн талаархи мэдээлэл: барилгын төмөр бетон каркасын ажил дууссан. парaped гадна дотор хана өрлөг, шавар, дээвэр, длтор засал, цонх суулгах ажил хийгдэж байна. ажлын гүйцэтгэл Гүйцэтгэл 60%-тай.



7.100-ортой эмнэлгийн барилга Барилгын мэдээлэл: Уг барилга нь тэнхлэгээрээ А-Блок 20.40х38.40м зоорийн давхартай 5 давхар, Б-Блок нь тэнхлэгээрээ 25.60х20.40м зоорьгүй 5 давхар, блок тус бүр лифттэй АБ-блок нь 1 давхарт

амбулатори, 2-4 давхартаа хэвтэн эмчлэх өрөө 5 давхартаа эмчилгээ, ариутгал, тоног төхөөрөмж зориулалттай.

Ажлын гүйцэтгэлийн талаархи мэдээлэл: барилгын төмөр бетон каркасын ажил дууссан дээврийн ажил 100%, гадна дотор хана өрлөгийн ажил 100%-тай фасадны ажил 100%, дотор засал 50%-тай холбоо дохиолол, сан, салхивч, цахилгаан дотор монтажны ажил 70%-тай лифт угсрах ажил 90%-тай хийгдэж байна. Гүйцэтгэл 75%-тай.



8. 2,3 дугаар багт тоглоом талбайн хийх тохижилтын ажил

Сүмбэр 2-р баг Мөнхийн гудамж, дэнжийн нуурийн зүүн хойд хэсэгт хуучин тоглоомын талбайг засварлах, шинээр тоглоомын талбай хийх ажил хийгдэж байна. ажил хийгдэж байна. ажлын гүйцэтгэл 45%-тай.



9. 1-р цэцэрлэгийн а-байрны барилгын их засвар

Хуучин барилгын дээвэр дотор хана заслын буулгалтын ажил хийгдэж дууссан. Дээвэр, фасад, дотор хана өрлөгсөн, цахилгаан, заслын ажил хийгдэж байна. ажлын гүйцэтгэл 60%-тай



10. Гомбосүрэн ноёны нэрэмжит гудамны талбайн тохижилт

Хуучин хашаа, хайс буулгах ажил 100% хийгдсэн. Шинээр явган зам талбайн хашаа хайсны ажил хийгдэж байна. ажлын гүйцэтгэл 60%-тай



11. угталт үдэлтийн хаалга

Хуучин зам талбайн хөшөө буулгах ажил хийгдсэн шинээр явган зам талбайн ажил, хаалганы ажил 60%-тай хийгдсэн байна.



12. 3 дугаарын багийн нийтийн эзэмшлийн талбайн, тохижилт тоглоомын талбай

Сүмбэр гарден соёл амралтын хүрээлэнд хийгдэх тоглоомын талбайн Газар шорооны ажил хийгдсэн, явган зам талбайн хашлага тавих ажил хийгдэж байна.



Барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн чиглэлээр:

Барилгын материалын лабораторийн чиглэлээр ХО-ажлаар хийгдэж байгаа барилга угсралтын ажлын материалуудад тогтмол дүн шинэжилгээ хийн ажиллаж байна. Угсралтын ажил 2020 оны 07 дугаар сард дууссан Цэцэрлэгийн барилга, Чойр хийдийн барилга, Авто замын ажлын бордюрын хашалтын дүүргэлт зэрэг ажлуудын бетоны бат бэхийн шинжилгээг тус тус хийж хариуг боловсруулсан. Мөн ХО ажлаар хийгдэж байгаа хүүхдийн тоглоомын талбайн хавтанд шинжилгээг хийж хариуг боловсруулан ажиллаж байна.

Бетон сорьцын бат бэхийг 7, 14, 28 хоногтойд
Нийт-7 удаагын шинжилгээ
шинжилгээ хийсэн

Зам талбайн хавтанд
нийт-2 удаагын



БУСАД:

Аймгийн Засаг даргын 2018 оны захирамжаар манай байгууллагад хариуцуулсан ногоон зурвас бүхий таримал модны талбайд Аймгийн Сум дундын ойн ангиас ирүүлсэн хуваарийн дагуу 2020 оны 07 дүгээр сарын 01-ний өдөр Захиргаа аж ахуй, Барилга хот байгуулалтын хэлтсийн албан хаагчид модны нүхийг тогоолж, усалгааг хийж гүйцэтгэсэн.

